



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/60

Амардалай

Газар эзэмших эрх дуусгавар
болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 31 дүгээр зүйлийн 31.1.3, Газрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын иргэн Т.Батмөнх (ШЕ:60121911)-ийн хүсэлтийн дагуу түүний 2 дугаар багийн нутаг дэвсгэрт өвөлжөө, хаваржааны зориулалтаар эзэмшиж байгаа (4811000550) "Дунд бууц"-ны 0.5 га, мод үржүүлгийн талбайн зориулалтаар эзэмшиж байгаа (4811000709) "Улаан дэл"-ийн 3.0 га газрын эзэмших эрхийг тус тус дуусгавар болгосугай.
2. Тус нэгж талбарын талаарх өөрчлөлтийг Газрын мэдээллийн цахим системд бүртгэхийг Газрын даамал (Л.Мөнхсарнай)-д үүрэг болгосугай.
3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 04 ний өдрийн А/05, 2018 оны 4 дүгээр сарын 30 ны өдрийн А/30 тоот захирамжийн хавсралтын Т.Батмөнхөд холбогдох хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

М.БАЯРСҮХ